| 1.13.3.1 | Салбарын хэмжээний журмын төсөлд санал өгөх | Үйл ажиллагаа | 1.Геопорталыг ажиллуулах журам<br>2.Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, түгээх, ашиглуулах журам<br>3.Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам<br>4.Байгууллагад ашиглагдах мэдээллийн технологийн журам | - Орон зайн өгөгдөл, мэдээллийг түгээх хэрэглүүлэх журмын төслийг боловсруулж, байгууллагын дэргэдэх Орон зайн мэдээлэл, технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр 2 удаа хэлэлцүүлсэн.<br>- MNS 6925 1-18:2021 стандартыг батлуулсан. ISO 19131, 19157 стандартуудыг боловсруулсан.<br>Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам 2017 оны А/253 тушаалаар батлуулсан. | **Эхний хагас жилд:**<br>1. Геопорталыг ажиллуулах журмын төсөлтэй танилцаж, холбогдох саналаа боловсруулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.<br>2. Салбарын төрийн архивын цахим системийг ажлуулах журмын төсөлтэй танилцаж, холбогдох саналаа боловсруулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.<br>3. Байгууллагад ашиглагдах мэдээллийн технологийн журмын төсөлтэй танилцаж, холбогдох саналаа боловсруулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>1. “Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын төсөлтэй танилцаж, холбогдох саналаа боловсруулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. | **Эхний хагас жилд:**<br>1. Геопорталыг ажиллуулах журам нь Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн дагалдах журам бөгөөд тухайн хуулийн төсөл шинэчлэгдэн боловсруулагдаж байгаа.<br>2. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/154 дугаар тушаалаар “Архивын цахим системийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамтай танилцаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.<br>3. “Салбарын мэдээллийн технологийг ашиглах дотоод журам”-ын төсөлтэй танилцаж, саналыг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 1/234 дугаар албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.<br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/160 дугаар тушаалаар тус журам батлагдсан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.<br>**Жилийн эцэст:**<br>1. Байгууллагын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журам нь Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн дагалдах журам бөгөөд тухайн хуулийн төсөл шинэчлэгдэн боловсруулагдаж байгаа.<br>2. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, түгээх, ашиглуулах журам нь Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, түгээх, ашиглуулах журмын төсөлтэй танилцаж, холбогдох саналаа боловсруулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. | тухай хуулийн дагалдах журам бөгөөд тухайн хуулийн төсөл шинэчлэгдэн боловсруулагдаж байгаа. | |
| 1.13.3.2 | “Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн журам”-ын төсөлд санал өгөх | Үйл ажиллагаа | 1 журам | Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2010 оны 402 дугаар тушаалаар “Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн журам”-ыг баталсан. | **Эхний хагас жилд:** Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулсан Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн журмын төсөлд санал өгсөн байна. | ГЗБГЗЗГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан цахим хэлэлцүүлэгт БХБ хэлтсийн дарга оролцож, Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйл “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын эрх, үүрэг”-ийг заасны дагуу бусад холбогдох хууль дүрэм журамд нийцүүлэн санал өгсөн. | 100 |
| 1.13.3.3 | “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм”-ийн төсөлд санал өгөх | Барилга, байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгө | 1 дүрэм | Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2010 оны 155 дугаар тушаалаар “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм”-ийг баталсан. | “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын дүрэм”-ийн шинэчилсэн төсөлд санал өгсөн байна. | ГЗБГЗЗГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан цахим хэлэлцүүлэгт БХБ хэлтсийн дарга оролцож, Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйл “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын эрх, үүрэг”-ийг заасны дагуу бусад холбогдох хууль дүрэм журамд нийцүүлэн санал өгсөн. | 100 |

## ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.1** | **Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ** | **Үйл ажиллагаа** | **Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн сангийн цахим үйлчилгээгээр хэрэглэгч байгууллага, иргэдийг хангах** | **Байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг хөтлөх журам батлагдсан.<br>Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн санг цахимаар шинэчлэх боломж бүрдсэн.** | **15 сумын 1:1000-ны масштатбай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зургийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна.** | **2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 1:1000-ны масштабтай байр зүйн зурагт хийгдсэн өөрчлөлт шинэчлэлтийг оруулан баяжилтийн мэдээг CD-гээр ГЗБГЗЗГ-т 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 1/474 тоот албан бичгээр хүргүүллээ.** | **100** |
| 2.1.1.1 | 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг, мэдээллийн санг шинэчлэх | Үйл ажиллагаа | Мэдээллийн сан | 2021 онд Геопортал үндэсний цахим системд улсын хэмжээний 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг хөрвүүлсэн. Шинэчлэлтийг 192.168.10.103 серверт хөтөлж байсныг ҮОЗӨДБ-ийн "Геопортал цахим систем"-рүү шилжүүлсэн. | 15 сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлнө.<br>1:1000-ны масштабтай байр зүйн зургийн шинэчлэлтийн тайлан, мэдээг холбогдох журмын дагуу хагас болон бүтэн жилээр ирүүлнэ. | Геопортал систем болон 1:1000-ны масштабтай байр зүйн зурагт 106 хашаа, 1263 метр шилэн кабелийн шугам, 6 олон нийтийн барилга, 14 амины орон сууцны барилгын шинэчлэлтийг хөтлөн явуулаад байна. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн бүрдлийг хангах ажлын хүрээнд хийгдсэн агаарын ортофото зураг болон бусад холбогдох ажлуудаар хийгдсэн гүйцэтгэлийн зураглалын мэдээллийг үндэслэн Геопортал цахим системд аймгийн төвөөс бусад 14 сумын тохижилт ногоон байгууламжийн 307 ногоон байгууламж, 751855 м2 зам, 358 байршилд 64908 м2 талбай, 45 байршилд 6380 м2 авто зогсоол, 863 ширхэг гудамж талбайн, гэрэлтүүлэг, 15 ширхэг усан оргилуур, 45 ширхэг хөшөө дурсгал, дулаан хангамжийн 20,9 км | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шугам, ариутгах татуургын 21,19 км 655 ширхэг цооног, ус хангамжийн 18,83 км шугам, цахилгаан хангамжийн 149,22 км шугам, 3281 ширхэг тулгуур, 48 дэд станцын зураглал, хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд зурагдаагүй 2184 барилга байгууламжийн зургийг шинэчлэн оруулсан. | |
| 2.1.1.2 | Инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг шинэчлэх | Үйл ажиллагаа | Цахилгаан дамжуулах шугам; Ариутгах татуургын шугам, худаг; Дулаан дамжуулах шугам, худаг; Цэвэр усны шугам, худаг Харилцаа холбооны шугам, худаг; Ус зайлуулах шугам, худаг; Шилэн кабель; | Шинэчлэлтийг 192.168.10.103 серверт хөтөлж байсныг ҮОЗӨДБ-ийн "Геопортал цахим систем"-рүү шилжүүлсэн. | 15 сумын инженерийн шугам сүлжээний зургийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлнө. Инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн тайлан, мэдээг холбогдох журмын дагуу хагас болон бүтэн жилээр ирүүлнэ. | "Геопортал цахим систем"-ийн мэдээллийн санд 106 хашаа, 1263 метр шилэн кабелийн шугам, 6 олон нийтийн барилга, 14 амины орон сууцны барилгын шинэчлэлтийг хөтлөн явуулаад байна. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн бүрдлийг хангах ажлын хүрээнд хийгдсэн агаарын ортофото зураг болон бусад холбогдох ажлуудаар хийгдсэн гүйцэтгэлийн зураглалын мэдээллийг үндэслэн Геопортал цахим системд аймгийн төвөөс бусад 14 сумын тохижилт ногоон байгууламжийн 307 ногоон байгууламж, 751855 м2 зам, 358 байршилд 64908 м2 талбай, 45 байршилд 6380 м2 авто зогсоол, 863 ширхэг гудамж талбайн, гэрэлтүүлэг, 15 ширхэг усан оргилуур, 45 ширхэг хөшөө дурсгал, дулаан хангамжийн 20,9 км шугам, ариутгах татуургын 21,19 км 655 ширхэг цооног, ус хангамжийн 18,83 км шугам, цахилгаан хангамжийн 149,22 км шугам, 3281 ширхэг тулгуур, 48 дэд станцын зураглал, хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд зурагдаагүй 2184 барилга байгууламжийн зургийг шинэчлэн оруулсан. | 100 |
| 2.1.1.3 | Байр зүйн зургийн шинэчлэлтийг шалгах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 15 сум | 2021 онд Геопортал үндэсний цахим системд улсын хэмжээний 1:1000-ны масштабтай байр | Геопортал үндэсний цахим системд хөрвүүлсэн 1:1000-ны масштабтай байр зүйн | 2019 онд хийгдсэн Ортофото зургийг ашиглан аймгийн Дэлгэрцогт, Дэрэн, Өндөршил, Хулд, Луус сумдын байр зүйн зургийн шинэчлэлтийг шалгах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зүйн зургийг хөрвүүлсэн. 2020 онд гүйцэтгэсэн “Төрийн өмчийн газрын тооллого, зураглал” гэрээт ажлын хүрээнд хүлээн авсан дроны зураг. | зургийн шинэчлэлтийг дроны зураг ашиглаж шалган, шинэчлэлтийн судалгаа гаргана. | ажлыг ГЗБГЗЗГ-ын заавар зөвлөмжийн дагуу гүйцэтгэж тайланг 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр \\192.168.20.24\ байршилд хүргүүлсэн. Шалгалтын үр дүнд дээрх 5 сумын байр зүйн зурагт нийт 86 барилга шинээр нэмэгдэж, 13 барилгын хэлбэр өөрчлөгдөж, 76 шинэ хашаа баригдаж, 134 хашааны хэлбэр хэмжээ өөрчлөгдсөн гэсэн үр дүн гарсан байна. | |
| 2.1.1.4 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх | Үйл ажиллагаа | Аймгийн цэг, тэмдэгтийн тоо | Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2021 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн. | Геодезийн байнгын цэг тэмдэгтийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлнө. | Цэг тэмдэгтийн тооллогын ажлыг 2022 оны 7 дугаар сард зохион байгуулж, Геопортал цахим системд 106 цэг тэмдэгтийн мэдээллийг заасврын дагуу шинэчилсэн. | 100 |
| **2.1.3** | **Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ** | **Улсын болон орон нутгийн төсөв, үйл ажиллагаа** | **Монгол орны газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулж, хэрэглээнд гаргах** | **1:100000-ны масштабтай байр зүйн зурагт орсон газар зүйн нэрийн мэдээллийн сан бий болгосон.**<br>**42 сумын газар зүйн нэрийн мэдээллийн сан цэг, шугам, талбайгаар үүсгэсэн.** | **Геопортал цахим системд 2020-2021 онд гүйцэтгэсэн газар зүйн нэрийн мэдээллийн сан хүлээн авч нэрийн мэдээллийн системд оруулсан байна.** | **Тус аймгийн хэмжээнд 2021 онд Геопортал цахим системд 16563 газар зүйн нэр орсон байна. Тус нэрийг Улсын Их Хурлаар батлагдсан эсэхийг шалган баталгаажуулах ажил хийгдсэн.** | **100** |
| 2.1.3.1 | Газар зүйн нэрийн мэдээллийн санг шинэчлэх | Үйл ажиллагаа | 1 мэдээллийн сан | 2021 онд Газар зүйн нэрийн мэдээллийн санг геопорталд оруулсан. | **Эхний хагас жилд:**<br>Геопортал цахим системд аймгийн хэмжээний газар зүйн нэрийн мэдээллийг засварлаж оруулна.<br>**Жилийн эцэст:**<br>Геопортал цахим системд аймгийн хэмжээний газар зүйн нэрийн мэдээллийг засварлан оруулж, цахим үйлчилгээ нэвтрүүлнэ. | Дундговь аймгийн хэмжээнд УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан нийт 14819 газар зүйн нэрийг Геопортал үндэсний орон зайн өгөгдлийн сан дахь 16563 газар зүйн нэрээс шүүх батлагдсан болон батлагдаагүй нэрсийн мэдээллийг цахим системд шинэчлэх ажлыг ГЗБГЗЗГ-аас 2022 оны 10 дугаар сард зохион байгуулсан сургалтын үеэр гүйцэтгэн засварласан .shp файлыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.4** | **Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлтийг цахимаар хүлээн авч баталгаажуулах** | **Үйл ажиллагаа** | **Баталгаажуулсан тайлангийн тоо, Газрын төлөв байдал, чанарын /захиалгат, төлөвлөгөөт/ хянан баталгааны ажлын нэгдсэн тайлан** | **Улсын хэмжээнд 8000 орчим иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрынхаа төлөв байдал чанарын захиалгат хянан баталгаа хийлгэсэн.** | **Газрын төлөв байдал, чанарын захиалгат болон төлөвлөгөөт хянан баталгааны ажлын тайланг нэгтгэж, Газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн тайланг гарган Засгийн газарт танилцуулсан байна.** | **2022 онд нийт 57 нэгж талбарын газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг цахим хэлбэрээр хүлээн аван, хянан шалгаж, дүгнэлтийг баталгаажуулсан.** | **100** |
| 2.1.4.1 | Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, байнгын шинжээчээр баталгаажуулах, мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих | Үйл ажиллагаа | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны эрхтэй мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн тайлан, дүгнэлтийн тоо | 2021 онд улсын хэмжээнд нийт 20,881 иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж, ашиглаж буй газарт захиалгат хянан баталгааны ажил хийгдэж, дүгнэлт баталгаажсан. | Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг улсын ерөнхий шинжээч болон байнгын шинжээчээр баталгаажуулсан байна. | 2022 онд нийт 63 нэгж талбарын газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг цахим хэлбэрээр хүлээн аван, хянан шалгаж 57 нэгж талбарын дүгнэлтийг баталгаажуулж, шаардлага хангаагүй 6 хянан баталгааг буцаасан. | 100 |
| **2.1.5** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн системийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөгжүүлэлтийн ажлыг хийх, хэрэглээнд нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа, Урсгал төсөв** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн системийг хөгжүүлсэн нэмэлт өөрчлөлтүүд** | **Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн системийн үйл ажиллагааны хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж боловсронгуй болсон байна.** | **Мэдээллийн системд газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр оруулж, программын хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.**<br>**Мэдээллийн сангаас газрын нэгдмэл сангийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хангасан.** | **100** |
| 2.1.5.1 | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг | Үйл ажиллагаа | Дундын мэдээллийн сан | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем | **Эхний хагас жилд:** Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд дулааны шугам сүлжээний газар 8 суманд 124 байршилд, цэвэр усны шугам 3 суманд 131 байршилд, бохир усны шугам 3 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх | | | | мэдээллийн санд бүртгэдэг болсон байна. | суманд 91 байршилд бүртгэж, газрын кадастрын мэдээлийн санд оруулахад бэлэн болоод байна. | |
| **2.1.6** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа** | **Газрын кадастрын мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Газрын кадастрын мэдээллийн санг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.** | **Сумдын Газрын даамлуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, тулгамдаж буй асуудлын талаарх хэлэлцүүлгийг 2022 оны 03 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулж, газрын даамлуудад Газрын нэгдмэл сангийн сангийн цахим систем, төрийн өмчийн газрын гэрээ байгуулах талаар газрын даамлуудад сургалт зохион байгуулж ажилласан. Мөн газрын даамлуудад газрын кадастрын мэдээллийн систем “Вэб” болон “Лэнд менежер” программ дээр ажиллах заавар зөвлөмжийг тогтмол өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч мэдээллийн санд хяналтыг тогтмол тавин ажиллаж байна.** | **100** |
| 2.1.6.1 | Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүртгэж, оруулах | Үйл ажиллагаа | Системийн хэрэглэгчид | Газрын кадастрын мэдээллийн сан | Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүртгэж, Улсын бүртгэлд бүртгэсэн байна. | Аймгийн хэмжээнд 2003 оноос хойш иргэн, аж ахуй нэгж, байгууллагад эзэмшүүлж, ашиглуулж, өмчлүүлсэн газрын нийт 24600 нэгж талбарын цаасан хувийн хэргийг цахимжуулж, Газрын кадастрын мэдээллийн сантай холбох ажлыг зохион байгуулан ГХГЗЗГ-ын даргын 2016 оны А/169 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нэгж талбарын хувийн хэрэг”-т байх шаадлагатай материалыг бүрдүүлж, аймгийн хэмжээнд 300,000 гаруй хуудас цаасан баримтыг цахимжуулсан. | 100 |
| 2.1.6.2 | Цахим системд бүртгэгдсэн хүсэлтийг тухай бүр хянаж, баталгаажуулах ажлыг | Үйл ажиллагаа | Системд бүртгэгдсэн хүсэлтийн тоо | Газрын цахим систем | Газрын цахим системд бүртгэгдсэн хүсэлтүүд тухай бүр Газрын | 2022 онд газрын кадастрын цахим системд нийт 2000 өргөдлийг бүртгэж шийдвэрлэсэн. Үүнд: шинээр газар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | | кадастрын мэдээллийн санд бүртгэгдэж, шийдвэрлэгдсэн байна. | өмчлөх 1045 иргэнд 77.59 га, шинээр газар эзэмших 285 иргэн, хуулийн этгээдэд 1473.1 га, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх 190 иргэн, хуулийн этгээдэд 60.96 га, шинээр газар ашиглах 7 ААН-д 968154.96 га газрыг цахим системд бүртгэж баталгаажуулсан.<br>Мөн газар эзэмших эрхээ цуцлах хүсэлт гаргасан болон 2 жил ашиглаагүй 15 иргэн, хуулийн этгээдийн 4.42 га газрын эзэмших эрхийг аймгийн Засаг даргын захирамжаар цуцалж, мэдээллийн санд дуусгавар болгосон.<br>61 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхээ барьцаалах хүсэлтийг мэдээллийн санд бүртгэсэн.<br>Улсын бүртгэлийн дундын мэдээллийн сангаас 390 иргэн, хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтын газар дээр улсын бүртгэлийн “Э” “А” дугаарыг авч газар эзэмших, ашиглах цахим гэрээ гэрчилгээг үүсгэсэн. | |
| 2.1.6.3 | Цахимаар ирсэн газартай холбоотой зөрчлийг арилгах, холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Хүлээн авч шийдвэрлэсэн зөрчлийн тоо | Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим систем | Цахимаар болон гар утасны аппликейшнээр ирсэн газартай холбоотой зөрчлийг арилгаж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлсэн байна. | Цахимаар болон гар утасны аппликейшнээр тус байгууллагад иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас газартай холбоотой зөрчлийн талаар өргөдөл ирээгүй. | 100 |
| 2.1.6.4 | Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх | Үйл ажиллагаа | Хамгаалалтын зурвасын тоо | Газрын кадастрын мэдээллийн санд нийслэлийн Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг оруулсан. | Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна. | Аймгийн хэмжээнд шилэн кабель 216,1 км, цахилгааны шугам сүлжээний 741,3 га газар, цэвэр усны шугам 26,9 км газрыг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж баталгаажуулаад байна. | 100 |
| 2.1.6.5 | Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн | Үйл ажиллагаа | Бүртгэгдсэн иргэн, | Хур системд холбогдсон газрын кадастрын | Газрын кадастрын мэдээллийн сангийн | Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу Газрын кадастрын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | системд иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг автоматжуулах | | хуулийн этгээдийн тоо | мэдээллийн сангийн нэгдсэн системийн автомат бүртгэгч | нэгдсэн системд иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг зөвхөн хурууны хээ уншигч төхөөрөмжийг ашиглан бүртгэж, баталгаажуулсан байна. | мэдээллийн сангийн нэгдсэн системд иргэн, хуулийн этгээдийн бүртгэлд хурууны хээний төхөөрөмжийг ашиглахгүй болсон. | |
| 2.1.6.6 | Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газрыг кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын тоо | Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системд | **Жилийн эцэст:** Улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрыг кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулсан байна. | Адаацаг сумын 4-р багт байршилтай Сүм хөх бүрдийн орчны газрыг улсын тусгай хэрэгцээнд авахаар 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган аймгийн ИТХ-аар хэлэлцүүлсэн.<br>Улсын тусгай хамгаалалтад авах саналыг БОАЖ-ын Сайдад хүргүүлсэн. | 100 |
| 2.1.6.7 | Хаягийн мэдээллийн сангийн өгөгдөл мэдээллийг засварлах, хаягийн мэдээллийн сангийн системийг эрхлэх | Үйл ажиллагаа | Хаягийн мэдээллийн нэгдсэн системийн нэгж талбарын тоо | Хаягийн мэдээллийн нэгдсэн систем | **Эхний хагас жилд:** Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн сангийн өгөгдөл мэдээллийг засварлаж дууссан байна. | Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэх, засварлах ажил хийгдэж дууссан ба иргэн, аж ахуй нэгж, байгууллагын мэдээг хаягийн мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан газрын кадастрын мэдээллийн санд 136 иргэн, 45 аж ахуй нэгж, 23 байгууллагын хаягийг баталгаажуулаад байна. | 100 |
| **2.1.7** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа, ургалт төсөв** | **Аймгийн хэмжээнд** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржийн системийг нэвтрүүлсэн** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.** | **Сумдын Газрын даамлуудад газрын биржийн систем болон Газрын кадастрын мэдээллийн системийн төлбөр, татвартай холбоотой мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөөг өдөр тутам өгч, 5 удаа албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Тухайлбал:**<br>**- Газрын даамлууд системийн Гэрээ хэсгийн "ТНА авах хүсэлт" хэсгийг хянаж, баталгаажуулах**<br>**- Газрын кадастрын системд газрын төлбөрийн 2022 оны нэхэмжлэл үүсээгүй нэгж талбаруудын төлбөрийн** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **нэхэмжлэлийг бүрэн үүсгэх**<br>- **Газрын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн дагуу газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг сумын Засаг даргаар батлуулах**<br>- **Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний худалдагдсан үнийг газар эзэмших, өмчлөх эрх шилжсэн тоогоор, санал болгож буй үнийг зарын дагуу судлан тухай бүр цахим биржид оруулах**<br>- **Газар эзэмших, ашиглах эрх шилжсэн болон шинээр газар эзэмшүүлж ашиглуулсан тохиолдолд газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг тухай бүр үүсгэж байх талаар тус тус чиглэл хүргүүлсэн.** | |
| 2.1.7.1 | Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах | Үйл ажиллагаа | Цахим системийн хэрэглээ | Газрын төлбөр, татварын систем | **Эхний хагас жилд:** Батлагдсан тогтоолыг Газрын төлбөр, татварын системд баталгаажуулах, тоон үзүүлэлтүүдийг бүртгэсэн байна. | Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтад нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан газрын төлбөр ногдуулах итгэлцүүрийг шинэчлэн тогтоох ажлыг Захиргааны ерөнхий тухай хуулийн дагуу зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тус аймгийн “Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээ”-г батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.<br>Уг тогтоолын дагуу аймгийн хэмжээнд хүчинтэй төлөвт байгаа нэгж талбарын газрын төлбөрийг шинэчлэн бодуулсан. | 100 |
| 2.1.7.2 | Газрын төлбөр, татварын ногдуулалтыг Татварын удирдлагын нэгдсэн системд | Үйл ажиллагаа | Татварын удирдлагын нэгдсэн | Газрын төлбөр, татварын систем | Хуульд заасан хугацаанд төлбөр, татварын ногдуулалтыг илгээх, | ГЗБГЗЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/194 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2022 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | илгээх, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээн авах ажлыг зохион байгуулах | | системд илгээсэн, системээс төлөлтийн мэдээлэл хүлээн авсан нэгж талбарын тоо | | төлөлтийн мэдээллийг цаг тухай бүр хүлээж авсан байна. | оны газрын төлбөрийн нэхэмжлэлийг сумдын ИТХ-аас 2018 онд тогтоосон итгэлцүүрийн дагуу хуулийн хугацаанд буюу 2022 оны 02 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд үүсгэн газрын төлбөрийг төвлөрүүлсэн.<br>2022 онд аймгийн хэмжээнд нийт 7081 нэгж талбарын ногдуулалтыг үүсгэж 6838 нэгж талбарын нэхэмжлэлийг үүсгэсэн. 1882 нэгж талбарын газрын төлбөрийн төлөлт бүртгэгдсэн байна.<br>Татвар төлөгчөөр бүртгэгдээгүй, газар эзэмшигч нас барсан, регистрийн дугаар зөрүүтэй, ТИН дугаар бүртгэлгүй зэрэг шалтгааны улмаас 243 нэгж талбарын нэхэмжлэл үүсээгүй байна.<br>2022 онд газрын төлбөрийн орлого 362 сая төгрөг төвлөрүүлэхээс 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 450,5 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн. | |
| 2.1.7.3 | Төлбөрийн даалгавар үүсгэн тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Эрхийн харилцаанд орж байгаа нэгж талбарын тоо | Газрын төлбөр, татварын систем | Үйлчилгээ үзүүлсний тоогоор тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. | Иргэн аж ахуй нэгж байгууллагын эзэмшил ашиглалтын газрын гэрчилгээ болон газар эзэмших барьцааны бүртгэл бүрт тэмдэгтийн хураамжийн нэхэмжлэлийг 96 иргэн аж ахуй нэгж байгууллага дээр үүсгэж татварын удирдлагын нэгдсэн системд илгээн орон нутгийн орлогот 960,000 төргөг төвлөрүүлсэн. | 100 |
| 2.1.7.4 | Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар иргэд, олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагаа | Цахим системийн хэрэглээ | Газрын төлбөр, татварын систем | **Эхний хагас жилд:** Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх боломжийг сурталчилсан байна. | - Газрын төлбөрөө газрын мэдээллийн сангийн цахим систем **www.egazar.gov.mn** сайтаар хэрхэн төлөх, харах талаар **гарын авлагыг** бэлтгэж байгууллагын **фэйсбүүк хуудас**, www.dundgovi.gazar.gov.mn **цахим хаягт** байршуулсан ба тус байгууллагын “Газрын харилцааны цахим үйлчилгээ” хэсэгт гарын авлагуудыг хэвлэж байршуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - “Цахим газрын харилцаа” 2 сарын аяны хүрээнд хуучны монгол киногоор хийсэн **шторкыг** байгууллагын фэйсбүүк хуудас болон цахим хуудсаар сурталчилсан.<br>- Газрын харилцааны Киоск машинаас иргэн, хуулийн этгээд газрын харилцаатай холбоотой нийт 42 төрлийн үйлчилгээг авах боломжтой болсон талаар болон газрын төлбөрөө хэрхэн шалгах, QR-аар төлөх талаар байгууллагын цахим хуудсаар болон Монголын үндэсний телевизээр мэдээлэл хийсэн. | |
| 2.1.7.5 | Газрын зах зээлийн үнийн мэдээллийг Газрын үнэлгээний системд оруулах, дүн шинжилгээ хийх | Үйл ажиллагаа | Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:** Хот, тосгон, бусад суурин газрын зах зээлийн үнийн мэдээллийг оруулсан байна.<br>**Жилийн эцэст:** Тариалангийн газрын зах зээлийн үнийн мэдээллийг оруулсан байна. | Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний худалдагдсан үнийг газар эзэмших, өмчлөх эрх шилжсэн тоогоор, санал болгож буй үнийг зарын дагуу судлан тухай бүр цахим биржид бүртгэж байна.<br>2022 онд Сайнцагаан сум 270, Эрдэнэдалай сум 23, Дэрэн сум 3, Өндөршил сум 6, Адаацаг 1, Баянжаргалан 3, Гурвансайхан 2, Дэлгэрцогт 8, Хулд 1 нийт 317 үнийн мэдээг цахим биржид бүртгэсэн байна.<br>Аймгийн төвийн сум болох Сайнцагаан сумын цахим биржид бүртгэгдсэн 2022 оны 132 үнийн мэдээг Газрын үнэлгээний системд шинэчилэн оруулсан ба 2018 оноос хойш нийт 434 газрын зах зээлийн үнийн мэдээг оруулсан байна. Хүчин зүйлсийн утгыг 4 бүлэг бүрээр уншуулж, системд оруулсан үнийн мэдээнд дүн шинжилгээ хийхэд мэдээлэл дутуу, алдаатай орсон зах зээлийн үнийн мэдээ байгаагүй болно. | 100 |
| 2.1.7.6 | Газрын үнэлгээний системийг ашиглан зам, | Үйл ажиллагаа | Нэгж талбарын тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:** Зам, шугам сүлжээний газрын | Аймгийн хэмжээнд 2179 нэгж талбарт 37,051 га талбайд зам, шугам | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шугам сүлжээний газрын чанарын болон эдийн засгийн үнэлгээг хийх | | | | суурь үнэлгээг тооцох (талбайн хэмжээгээр) боломжийг судалж газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй зам, шугам сүлжээний газрын судалгаа гаргасан байна. **Жилийн эцэст:** Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй байгаа зам, шугам сүлжээний газрын эдийн засгийн үнэлгээг хийсэн байна. | сүлжээний газарт үнэлгээ хийсэн. | |
| 2.1.7.7 | Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо | Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | Тухайн жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар төлөвлөсөн газарт зохион байгуулсан байна. | Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар олгохоор тусгагдсан 56 байршилд 78 удаа дуудлага худалдааг цахимаар зохион байгуулснаас 22 дуудлага худалдааг дахин зарласан ба 26 дуудлага худалдаа амжилттай болж, 52 дуудлага худалдаа үнэ төлөөгүй, оролцогчгүй зэрэг шалтгааны улмаас хүчингүй болсон.<br>Танхимаар дуудлага худалдаа зохион байгуулаагүй.<br>Аймгийн хэмжээнд 9 байршилд салхин сэнсний судалгааны талбайн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын дагуу зохион байгуулж, гэрээг байгуулан тухайн шатны Засаг даргын захирамжаар газар ашиглуулсан.<br>Тус аймгийн дуудлага худалдааны орлогын дансанд (100080000967 Ду.Газрын дуудлага худалдааны орлого) газрын дуудлага худалдааны орлого, дэнчин, газрын суурь үнийг төвлөрүүлдэг.<br>Газрын дуудлага худалдаа, газрын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурь үнийн орлого 88 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээс газрын дуудлага худалдаанаас 74,8 сая төгрөг, газрын суурь үнэ 83,0 сая төгрөг, нийт 157,8 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна. | |
| 2.1.7.8 | Газар өмчлөгч, эзэмшигчийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар худалдах хүсэлтийн дагуу дуудлага худалдаа зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн тоо | Газрын биржийн цахим системээр иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу дуудлага худалдаа зохион байгуулах боломж бүрдсэн. | Газар өмчлөгч, эзэмшигчийн газар өмчлөх, эзэмших эрхээ дуудлага худалдаагаар худалдах хүсэлтийн дагуу дуудлага худалдаа зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд эзэмшил, өмчлөлийн газраа дуудлага худалдаагаар худалдах хүсэлт ирээгүй байна. | 100 |
| 2.1.7.9 | Газрын биржийн цахим програм хангамжаар дамжуулан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, олон нийтэд үйлчлэх | Үйл ажиллагаа | Эрх шилжсэн нэгж талбарын тоогоор үнийн мэдээ нэмж бүртгэнэ. | Газрын биржийн цахим системд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэх боломжтой болсон. | Газрын эрх шилжсэн нэгж талбарын тоогоор газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын биржийн цахим системд бүртгэсэн байна. | Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний худалдагдсан үнийг газар эзэмших, өмчлөх эрх шилжсэн тоогоор, санал болгож буй үнийг зарын дагуу судлан тухай бүр цахим биржид бүртгэсэн.<br>2022 онд Сайнцагаан сум 270, Эрдэнэдалай сум 23, Дэрэн сум 3, Өндөршил сум 6, Адаацаг 1, Дэлгэрцогт 8, Хулд 1, Гурвансайхан 2, Баянжаргалан 3 нийт 317 үнийн мэдээг цахим биржид тухай бүр бүртгэн олон нийтэд нээлттэй мэдээлсэн. | 100 |
| 2.1.7.10 | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, замд нэр өгөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан гудамж, замыг мэдээллийн санд бүртгэх | Үйл ажиллагаа | Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем | Хаягийн мэдээллийн нэгдсэн системд 1181 гудамж бүртгэгдсэн. | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, замд нэр өгөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулж, гудамж, замыг хаягийн мэдээллийн санд бүртгэсэн байна. | Сайнцагаан сумын ИТХ-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 42 тоот тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор тус тус гудамж, зам талбайд нэр өгч хаягийн мэдээллийн санд баталгаажуулсан.<br>2022 онд шинээр гудамж зам талбай нэмэгдээгүй байна. | 100 |
| 2.1.7.11 | Аймгийн хэмжээнд кадастрын мэдээллийн санд | Үйл ажиллагаа | Нэгж талбарын тоо | Хаягийн мэдээллийн нэгдсэн системд 22360 | **Эхний хагас жилд:** Аймгийн хэмжээнд хаяг | Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэх, засварлах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүртгэлтэй холбогдох хууль, журмын дагуу хаяг олгогдоогүй нэгж талбарт хаягийн мэдээллийн системээр хаяг олгож, баталгаажуулах | | | нэгж талбарыг хаягжуулсан. | олгогдоогүй нэгж талбарын судалгааг бүрэн гаргасан байна. **Жилийн эцэст:** Хаяг олгогдоогүй нэгж талбаруудад хаяг олгож баталгаажуулсан байна. | ажил хийгдэж дууссан ба иргэн, аж ахуй нэгж, байгууллагын мэдээг хаягийн мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан газрын кадастрын мэдээллийн санд 136 иргэн, 45 аж ахуй нэгж, 23 байгууллагын хаягийг баталгаажуулаад байна. | |
| **2.1.8** | **Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санг нэвтрүүлсэн** | **Газрын нэгдмэл сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.** | **Сумдын Газрын даамлуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, тулгамдаж буй асуудлын талаарх хэлэлцүүлгийг 2022 оны 03 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулж, газрын даамлуудад Газрын нэгдмэл сангийн сангийн цахим систем, төрийн өмчийн газрын гэрээ байгуулах талаар газрын даамлуудад сургалт зохион байгуулж ажилласан. Мөн газрын даамлуудад газрын кадастрын мэдээллийн систем “Вэб” болон “Лэнд менежер” программ дээр ажиллах заавар зөвлөмжийг тогтмол өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч мэдээллийн санд хяналтыг тогтмол тавин ажиллаж байна.** | **100** |
| 2.1.8.1 | Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгах, Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажсан нэгж талбарын тоо | Газрын кадастрын мэдээллийн систем | Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна. | ГЗБГЗЗГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 1/1765 дугаар албан бичгийн дагуу Төрийн өмчийн газрыг зурагжуулах бүртгэн баталгаажуулах ажлын үр дүнгээр аймгийн хэмжээнд үүссэн зөрчилтэй нэгж талбаруудаас 513 нэгж талбарын зориулалтыг зассан, 308 нэгж талбарыг мэдээллийн санд шинээр бүртгэсэн, 744 нэгж талбарын буруу орсон байршилыг засварласан, 2023 оны төлөвлөгөөнд тусгасан 33 нийт 1565 нэгж талбарын зөрчлийг арилгаж, тайланг 10, 12 дугаар саруудад ГЗБГЗЗГазарт хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа газрын хэмжээ зөрүүтэй 65 иргэн, аж ахуй нэгж, байгууллагын 4.29 га газрын талбайн хэмжээг өөрчлөн зөрчлийг арилгасан. | |
| 2.1.8.2 | Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажиллах | Үйл ажиллагаа | Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан байна. | Төрийн өмчийн газрын мэдээллийн сан | **Эхний хагас жилд:** Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан байна. **Жилийн эцэст:** Төрийн өмчийн газрын хариуцагчтай байгуулсан гэрээг мэдээллийн санд баталгаажуулсан байна. | Газрын нэгдмэл сангийн цахим системд Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулах аймгийн Засаг дарга болон 15 сумын Засаг дарга нарын мэдээллийг бүртгэж баталгаажуулсан. | 100 |
| 2.1.8.3 | Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах, мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах | Үйл ажиллагаа | Мэдээллийн санг хөтөлж ажилласан байна. | Газрын нэгдмэл сангийн мэдээллийн сан | Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд газрын нэгдмэл сангийн ангилалд өөрчлөлт орсон тухай бүх өөрчлөлтийг оруулж, мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна. | Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системд газрын нэгдмэл сангийн газрууд ангилал тус бүрээр орж, программын хөгжүүлэлтийн ажил хийгдэж, мэдээллийн сангаас газрын нэгдмэл сангийн тайланг гаргах бэлтгэл ажлыг хангасан. | 100 |
| **2.1.9** | **Салбарын хэмжээнд сүлжээ, техник, програм хангамж, системийн хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах** | **Үйл ажиллагаа, урсгал төсөв, хөрөнгө оруулалт** | **Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа** | **Байгууллагын дотоод сүлжээ домэйн удирдлагын системд холбогдсон. Байгууллага, нийслэл, 21 аймаг тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтод холбогдсон. Мэдээллийн аюулгүй байдлын газрын Төрийн хамгаалагдсан нэгдсэн сүлжээнд холбогдсон.** | **Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна.** | **Байгууллагын сүлжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмж болон мэдээллийн систем, програм хангамжийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангаан ажиллаж байна.** | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **Байгууллага, нийслэл, 21 аймаг, 345 цэг /сум, суурин, GNSS БАС/ интернэтийн сүлжээнд холбогдсон.** | | | |
| 2.1.9.1 | Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагаа, урсгал төсөв | Нийт сум, тосгоны Газрын даамлын VPN тусгаарласан сүлжээ, аймгийн сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа | Аймаг тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтод холбогдсон. | **Эхний хагас жилд:** Сүлжээ хэвийн, найдвартай, аюулгүй ажиллаж байгууллага, салбарын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна. **Жилийн эцэст:** Сүлжээ хэвийн, найдвартай, аюулгүй ажиллаж байгууллага, салбарын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна. | Байгууллагын дотоод сүлжээ болон ГЗБГЗЗГазартай холбогдсон тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтын VPN сүлжээ, хиймэл дагуулын мэдээ хүлээн авах станц, сумдын даамлуудад ашиглагдаж буй гэр интернет төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, шаардлагатай тохиолдолд ГЗБГЗЗГ-ын ОЗМТХэлтэс болон Unitel-тэй холбогдож, арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулж ажилласан. | 100 |
| 2.1.9.2 | Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах | Үйл ажиллагаа, урсгал төсөв, хөрөнгө оруулалт | - Техник, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа | - Хэвийн үйл ажиллагаанд саатал гарсан тухай бүрд техник засвар үйлчилгээг цаг алдалгүй хийж хэвийн ажиллагааг хангасан.<br>- Байгууллагад хэрэглэгдэж буй бусад техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, ажиллагааг хангаж ажилласан. | **Эхний хагас жилд:** Байгууллагад хэрэглэгдэж буй техник, программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа хангагдсан байна. Шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг шуурхай үзүүлсэн байна. **Жилийн эцэст:** Байгууллагад хэрэглэгдэж буй техник, программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа хангагдсан байна. Шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг хийх, шинэчлэх. | ГЗБГЗЗГ-ын даргын 2022 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн А/160 дугаар тушаалаар батлагдсан “Салбарын мэдээллийн технологийг ашиглах дотоод журам”-ын дагуу байгууллагад ашиглагдаж буй компьютер, түүний дагалдах тоног төхөөрөмжүүдэд бүртгэл үүсгэн, эвдрэл гэмтэл, хэвийн ажиллагаа алдагдсан тохиолдолд засвар үйлчилгээг хийн тухай бүр техник хангамжийн карт хөтлөн ажилладаг.<br>Техник хангамжийн картын бүртгэлд 13 компьютер бүртгэн үйлдлийн системийг шинэчилж, шаардлагатай программ хангамжийг суулгасан. Мөн 3 ширхэг гурван үйлдэлт принтер, 5 ширхэг скайнер, maxhub ухаалаг дэлгэц, киоск зэрэг 43,1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч шинэчлэлт хийсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
